



АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	3
1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ	5
1.3 ТӨСЛИЙН ОНОВЧЛОЛТ, ХҮЧИН ЧАДАЛ	6

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ НӨХЦӨЛ 10

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 12

3.1. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛ	13
3.2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	14
3.3. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	15
3.4. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	16

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ 17

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 19

5.1. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	20
5.2. УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	21
5.3. ХӨРСӨН БҮРХЭВЧ, ГАЗРЫН ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	24
5.4. УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	26
5.5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
5.6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
5.7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
5.8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	33
5.9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	34
5.10. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	37
5.11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	38
5.12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	39
5.13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ	40



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн солбицол
- Хүснэгт 2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд
- Хүснэгт 3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний ажлууд
- Хүснэгт 4. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд
- Хүснэгт 5. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах ажлууд
- Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- Хүснэгт 7. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө
- Хүснэгт 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
- Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- Хүснэгт 11. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
- Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
- Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах хуваарь /2025 он/
- Хүснэгт 14. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв



НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Жи Эйч Пи” ХХК нь 2020 оны 2 дугаар сараас өөрсдийн санаачлагаар Өвөрхангай аймгийн Уянга сумын нутгаар урсах Онги гол дээр УЦС-ыг хувийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах, улмаар үйлдвэрлэсэн ЦЭХ-ийг түгээх сүлжээнд нийлүүлэх зорилготойгоор УЦС баригдах нутаг дэвсгэртэй сайтар танилцах, хамгийн боломжит байршлыг урьдчилсан байдлаар сонгож, судалгаа, тооцооны ажлыг гүйцэтгэсэн байна.

Үүнд:

- Байрзүйн судалгаа
- Геофизикийн судалгаа
- Геологийн өрөмдлөг
- Геодезийн өгөгдөл
- Ус зүйн судалгаа
- Эрчим хүчний зах зээлийн судалгаа
- Далан барих газрын геологийн нөхцөл байдлын судалгаа
- Усан сан, усны барилга байгууламжийн тооцоо судалгаа
- Чичирхийллийн судалгаа, газар хөдлөлийн тохиолдлыг тооцоо
- Байнгын ажиллагаатай усан сан бүхий УЦС-ыг ажиллуулах нөхцөлийг хангахын тулд турбины тоог оновчтой сонголт.
- Эдийн засаг, санхүүгийн шинжилгээ

3 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, суурь судалгааг хийхдээ Монгол улсын эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Барилгын тухай хууль, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тухай хууль, Усны хууль, усны барилга байгууламж болон эрчим хүчний салбарт мөрдөгдөж буй барилгын норм ба дүрэм, улсын стандарт, заавар журам зэрэгт нийцүүлэн барилга байгууламжийн үндсэн үзүүлэлтийг тооцоолох тооцооны аргачлалыг ашигласан байна.

Мөн усан цахилгаан станцын хүчин чадал, хөрөнгө оруулалт, үр ашиг, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хамгийн зохистой ашигтай хувилбарыг сонгосон. Бага оврын УЦС нь усны эрчим хүчний төхөөрөмжийг суурилуулах замаар бага хэмжээтэй цахилгаан эрчим үйлдвэрлэдэг станц юм. Чухам ямар станцыг “Бага оврын усан цахилгаан станц” гэх талаар нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэр томъёо хараахан гараагүй байна. Орон бүр өөр өөрийн онцлог байдлаас хамааран БОУЦС-ын чадлыг өөр өөрөөр томъёолж байна.

Дэлхийн хэмжээнд 1-10 МВт хүчин чадалтай усан станцыг “Бага оврын УЦС” ангилалд хамруулдаг байна. Олон улсын хүрээнд БОУЦС-ын дээд хязгаар нь 10 МВт байдаг ба зарим оронд 20 МВт байдаг. Хамгийн том нь Хятад улсад байгуулагдсан ба БОУЦС нь 50 МВт хүртэл чадалтайгаар байгуулагдсан байна.

Усан сан бүхий бага оврын УЦС нь:

- УЦС-ын үйлдвэрлэсэн 1кВтц цахилгаан эрчим хүчний өртөг нь /ижил чадлын далантай станцуудтай харьцуулахад/ бага байдаг.



- Бүс нутагтаа усан сан үүсгэснээр уур амьсгалын болоод байгаль орчны таатай нөхцөл үүсгэнэ. Ялангуяа бүс нутагт цэвэр усны нөөц бүрдүүлнэ.
- Хамгийн ач холбогдолтой тал нь ийм төрлийн бага оврын УЦС-ын барилгын ажил төслийн талбарын гидрогеологийн анхны нөхцөлд үзүүэх нөлөө бага юм.

3 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц баригдсанаар 2.9 км² толион талбай бүхий хиймэл нуур үүсэх ба өмнө Монголд баригдсан Тайшир, Дөргөний УЦС-уудын жишгээр ажлын байр нэмэгдэх, уур амьгал зөөлөрч аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой болох, загасны аж ахуй эрхлэх зэрэг эдийн засгийн хувьд орон нутагт үр ашигтай. Онги голын УЦС-ын станцын барилга дотор 2 (хоёр) 1.0 МВт, 2 (хоёр) 0.5 МВт үндсэн нийт 4 агрегаттай байхаар төлөвлөсөн. Энэхүү агрегатууд нь байгаль орчны тэнцвэрийг хадгалах урсацыг далангаас доош гаргаж байхаар төлөвлөсөн.

УЦС-ын тоног төхөөрөмж нь турбин, генератор, өсгөх трансформаторууд, гидромеханик тоног төхөөрөмж зэрэг бүх төрлийн цахилгаан механик хийгээд туслах тоног төхөөрөмжөөс бүрдэнэ. Тус цахилгаан станцын ашиглалтын түрэлт 20 м орчим байх учраас синхрон генераторт шууд холбосон босоо тэнхлэгтэй франсис турбинуудыг сонгож авсан.

Турбины оролт болгон дээр эрвээхий хэлбэрийн үндсэн орох хаалт суурилуулагдах ба энэ нь тус агрегатыг зогсоож, засвар үйлчилгээ хийх нөхцөлүүдэд тусгаарлах зориулалттай. Генераторуудыг станцын барилгын доод талд гадаа байрладаг өсгөх трансформаторуудад холбоно. Трансформаторуудын өндөр хүчдэлийн талыг Уянга сумын 35\0.4 кВ-ын дэд станцын 35 кВ-ын талд 35 кВ-ын хоёр хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбоно.




1.2 Төслийн байршил. “3 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц” төслийн талбай нь Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос баруун зүгт 500 км, Өвөрхангай аймгийн Арвайхээр хотоос Уянга сум хүртэл баруун зүгт 80 км, Уянга сумын төвөөс зүүн урд 8-10 км-т байрлана.

Хүснэгт 1.

Талбайн булангийн цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
1	102	22	55.74	46	27	46.46
2	102	22	43.23	46	27	46.45
3	102	22	23.97	46	27	46.46
4	102	22	49.64	46	27	46.46

Зураг 1. Төслийн талбайн байршил




Зураг 2. Төслийн талбайн харагдал байдал




1.3 Төслийн оновчлолт, хүчин чадал. Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Онгийн голын хөндийд Уянга сумаас доош 9 км-т орших Цэцэнгийн голын цутгал хэсэгт Булагт уул, Холбоо хүрэн уулын нарийссан хавцал хэсэгт Булагт уулын бага оврын УЦС барих газрыг сонгон авсан. Голын урсгалыг хөндлөн боож усыг хуримтлуулах байгууламжийг боомт гэнэ. Харин голын усыг хашиж чиглүүлж байвал далан гэнэ. Гол дээр барьсан боомтын тэнхлэгийг хөндлүүр гэж нэрлэнэ. Энэ хавцал хэсэгт УЦС-ын боомт барих гурван хөндлүүр байна.

1. Эхний хөндлүүр нь Булагт уулын урд бэл Холбоо хүрэн уулын түрж орсон хошуу хэсгийг холбосон хэсэг. Энд Булагт уулаас Цэцэнгийн гол орж ирэн Онги голд цутгах тул Цэцэнгийн хөндлүүрт газар дараах хоёр байдлаар боомт төлөвлөж болно. Үүнд:


А. 260 м урттай далайн түвшнээс дээш 1942 м-ээс 1954 м хүртэл 12 м өндөртэй боомт баригдах ба 6371 м приметртэй, 1.39 км² мандлын талбай бүхий хиймэл нуур болно.





Зураг 4. Булагт уулын УЦС 14м өндөртэй боомт байгуулах Цэцэнгийн хөндлүүр


2. Булагт уулын хоёрдох хөндлүүр нь Онгийн гол Холбоо хүрэн уулын урагш түрж орж ирсэн хошууг даган урсах хясааг холбосон хэсэг байна. Энэ хөндлүүрийн урт нь 350 м урт бөгөөд 1944-1956 м өндөржилт хооронд 12 м өндөртэй боомт баригдах боломжтой. Энэ хөндлүүрт боомтыг 1944-1958 м хүртэл өндөрлөж 14 м өндөр боомт барих боломжтой.



Зураг 5. Уянга Онги голын бага оврын УЦС-ын Булагт уулын хөндлүүр



3. Уянга сумаас доош хамгийн ойр орших Онги голын гуравдах хөндлүүр нь 700м урттай 1949м сууриас 1966м өндөржилт хүртэл 17-18м өндөр боомт босгох боломжтой. Энд 17-18м өндөртэй боомт босгох боломжтой байна. Хэрэв УЦС-ыг Булагт уулын Цэцэн голын орж ирдэг ам Онги гол рууцутгах хүртэл хоолойгоор явуулбал 1942-1966 буюу 24м уналттай болж илүү их эрчим хүч үйлдвэрлэх боломжтой болно.



Зураг 6. Булагт уул, Холбоо хүрэн уулын хөндлүүр

Эдгээр гурван хөндлүүр тус бүр нь өөр өөрийн уртын хэмжээ болон бүсгож болох боомтын өндрийн хэмжээгээр ялгаатай байна. Хамгийн бага хөрөнгө оруулалт шаардах нь Цэцэн голын цутгал хэсэгт баригдах УЦС бөгөөд энд 260 м урттай, 12 м өндөр боомт барих боломжтой. Гэхдээ гаргах хүчин чадал хамгийн бага 240КВт байх болно.

$$N = 9.81 * \eta * Q * H = 9.81 * 0.95 * 2 * 12 = 224KВт$$

Булагт уулын хөндлүүр нь 14м түрэлт үүсгэж


$$N = 9.81 * \eta * Q * H = 9.81 * 0.95 * 2 * 14 = 261KВт$$

Хамгийн өндөр их хүчин чадалтай нь Холбоо хүрэн уулын хөндлүүр бөгөөд энд

$$N = 9.81 * \eta * Q * H = 9.81 * 0.95 * 2 * 24 = 450KВт \text{ болно}$$

Онги голын олон жилийн урсцын ажиглалтын материалд дурдаснаар хамгийн их урсац нь $30.1\text{м}^3/\text{с}$ болж байсан байна. Ийм урсацтай үед үерийн усыг хаяхгүйгээр турбинаар өнгөрүүлнэ гэвэл.

$$N = 9.81 * \eta * Q * H = 9.81 * 0.95 * 30.1 * 24 = 6232KВт = 6.23МВт \text{ болно.}$$



Зураг 7. Онгийн голын хөндлүүрүүд усанд автагдах усан сангийн талбайн хэмжээ



ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ НӨХЦӨЛ

Уур амьсгал. Аймгийн нийт нутгийн 23.0 хувь нь хангайн, 28.2 хувь нь тал хээрийн, 48.8 хувь нь говийн бүсэд оршдог. Байгаль цаг уурын хувьд эрс тэс, эх газрын уур амьсгалтай, өвөлдөө хангайн бүсээр -40-43 хэм, тал хээр, говийн бүсээр -35-39 хэм хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь хангайн бүсээр 14-17 хэм, тал хээр, говийн бүсээр 18-22 хэм хүрдэг. Салхины хурд 5-8 м/сек, жилд дунджаар 198.8 мм хур тунадас унадаг. Жилийн хамгийн дулаан VII сард, харин хамгийн хүйтэн I сард тус тус ажиглагддаг байна. 2000-2019 хугацаанд агаарын үнэмлэхүй хамгийн их 2017 оны VII сард 34.00C хүртэл халж, харин уулсын хоорондох тал хөндийд хүйтэн байдаг ба үнэмлэхүй хамгийн бага 2000 оны 1-р сард -31.50C хүртэл хүйтэрсэн байна. Уянга сум орчимд өвөлдөө -13.-180C, хавар -1 40C, зун 13-170C, намар -2...20C орчим байдаг байна

Уулзүй: Уянга сумын нутаг дэвсгэр нь Монгол орны Физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их муж, Хангайн мужийн Хангайн гол нуруу тойрогт хамаарна. Өвөрхангай аймгийн Уянга сум нь Хангай, тал хосолсон өндөршлийн хувьд далайн түвшнээс дээш 1700-3025 м өргөгдсөн Онги, Таац зэрэг Хангайн нуруунаас эх авсан томоохон голуудтай. Нутаг дэвсгэрийн 30% орчим хувийг ой мод эзэлдэг. Хангайн нурууны уул зүйн бүдүүвчээс үзвэл судалгааны талбай нь Дорнод Хангайн уул зүйн их мужлалын /хамгийн/ зүүн, зүүн өмнөд хэсэгт байрлах ба талбайн өмнөд Тарагт орчмын хэсэг Өмнөд Хангайн нам уулын их мужлалын зүүн захад хамаарагдана. Дорнод Хангай нь янз бүрийн чиглэлийн тэдгээрийн дотор баруун хойш чиглэлийн нурууд зонхилсон өндөр уул нуруудын тогтолцоо бөгөөд өмнөд Хангайн бэсрэг уулс нь жижиг толгодлог уулс, баруун хойш чиглэлийн салангид нурууд хотгорууд бүхий уул зүйн элементүүдээс тогтоно. Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1931-2078 метрийн үнэмлэхүй өндөрт, газрын гадаргын хэвгий буюу налуу нь районд 0.00-10.2 (градус)-т байна.

Ус зүй: Төслийн талбай нь ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай сав, Онги голын сав газарт багтах ба талбайн дундуур тогтмол урсах Онги гол урсаж байна. Харин талбайд булаг шанд байхгүй. Онги голын эх Хангай нурууны өврөөс эх авч Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан, Тарагт, Арвайхээр Баянгол, Дундговь аймгийн Сайхан-Овоо, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумдын нутгаар дамжин Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Булган сумдын заагт орших 175 км² талбай бүхий Монголын говийн экологийн тэнцвэрийг хадгалахад онцгой нөлөөтэй, нууруудын хөндийн хамгийн зүүн талын том нуур болох Улаан нуурт цутгадаг. Монгол орны Төв Азийн гадагшаа урсгалгүй ай савын томоохон голуудын нэг бөгөөд Онги Таацын сав газар хамрагдана.

Голын ус хурах талбай 160276 км², урт нь 437 км, ус хурах талбайн дундаж өндөр 1650 м, голдирлын ерөнхий хэвгий 5.6%. Онги голын сав газар дахь газрын доорх усны сав нь 39201.5 хавтгай дөрвөлжин км талбайтай. Хангайн нурууны өврөөс эх авдаг Онги гол, түүний адагт байрладаг Улаан нуурыг хамарна. Онги голын сав газар дахь газрын доорх усны нөхөгдөх нөөц нь Онги голын хөндийн зарим хэсэг, Хангайн нурууны өврөөр тархсан түрмэл чулуулаг дахь ан цавлаг бүс, зарим хуурай сайрын хөндийг дагаж хуримтлагдсан шинжтэй байна. Тус сав газар дахь газрын доорх усны нийт 396 сая шоо м нөхөн сэргээгддэг нөөц байгаа тооцоо гарсны дотор уг нөөцийн зонхилох хэсэг нь тун бага буюу нэг ам км талбайд 0-5 мм/жил/км² нөхөн



сэргээгддэг нөөцтэй талбайд хамрагдаж байна. Ай савын нийт 39201 ам км талбайн 28613 ам км буюу 72.9 хувьд нь тун бага (0-5 мм/ам км) нөхөн сэргээгддэг, 143 сая м3 нөөц буюу нийт нөхөн сэргээгддэг нөөцийн нь 36.1 хувь нь бага нөхөн сэргээгддэг нөөцтэй, (5-10 мм/ам км) 1571 ам км талбайд 12 сая м3 нөхөн сэргээгддэг нөөц буюу нийт нөхөн сэргээгддэг нөөцийн нь 3.0 хувь, багаас дундаж нөхөн сэргээгддэг нөөцтэй (10-20 мм/ам км) 3699 ам км талбайд 55 сая м3 нөхөн сэргээгддэг нөөц буюу нийт нөхөн сэргээгддэг нөөцийн нь 13.8 хувь, дундаж нөхөн сэргээгддэг нөөцтэй (20-50 мм/ам км) 1000 ам км талбайд 35 сая м3 нөхөн сэргээгддэг нөөц буюу нийт нөхөн сэргээгддэг нөөцийн нь 8.8 хувь, нийлмэл урсац бүхий нөхөн сэргээгддэг нөөцтэй (30 ба 40 мм/ам км) 4318 ам км талбайд 151 сая м3 нөхөн сэргээгддэг нөөц буюу нийт нөхөн сэргээгддэг нөөцийн нь 7.8 хувь тус тус болж байна.

Амьтан: Өвөрхангай аймгийн хөхтөн амьтны тархац, нөөцийн үнэлгээг 2023 онд байгаль орчны мэргэжлийн байгууллага хийсэн бөгөөд тус судалгаагаар Уянга сумын нутагт 31000 км² талбайд 0.4 бодгаль амьтны нягтшилтайгаар 20 орчим янгир ямаа, 725000 км² талбайд 0.1 бодгаль амьтны нягтшилтайгаар 50 орчим халиун буга тархсан бол төслийн талбайгаас зүүн зүгт Зүүнбаян-Улаан сумын нутагт Баян-Улаан ууланд цөөн тооны (10 орчим) аргаль хонь бий. Тухайн бүс нутагт 32 зүйлийн хөхтөн амьтан, 50 орчим зүйлийн шувуу, 1 зүйл хоёр нутагтан, 5 зүйлийн мөлхөгчид, 3 зүйлийн загас бүртгэгдээд байна.

Ургамал. Төслийн талбайн нутаг дэвсгэр нь Монгол орны байгалийн мужлалаар нутаг хээрийн бүсэд багтана. Судалгаанд хамрагдсан нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар (Юнатов,1950) Евразийн хээрийн их муж, Хангайн уулын ойт хээрийн хошуу, Өмнөд Хэнтийн уулын хээрийн тойрогт хамаарагдана. Бидний судалгааны цэгт уулын хээр, хуурай хээр, бүс дундын ургамалжилт тааралдана. Төслийн талбайд болон түүний ойр орчмын нутагт хийсэн судалгааны үр дүнд нийт 22 овог, 46 төрөлд хамаарагдах 57 зүйлийн ургамал бүртгэгдсэн байна. Овгуудын дотроос үетний овог -14 зүйл, нийлмэл цэцэгтэн-8 зүйл, тэргүүлэгч цэцэгтний овог- 5 зүйл, улалж, лууль, холтсон цэцэгтэн, буурцагтан зэрэг овгууд тус бүр -3 зүйл, бусад овог 1-2 зүйл ургамалтайгаар тохиолдож байна. Түүнчлэн зүйлүүдийн дотроос сөөгөнцөр-2, нэг наст ургамал 5 зүйл байгаа бөгөөд 50 зүйл олон наст ургамал ургаж байна. Төслийн талбайн хэмжээнд эмийн болон ашигт ургамал -24 зүйл, хадлан бэлчээрийн ургамал-57 зүйл, хөл газрын ургамал 5 зүйл тохиолдоно.

Суурин газар, зам харилцаа. Төсөл хэрэгжих Өвөрхангай аймгийн Уянга сум нь нутаг дэвсгэрийн хэмжээ нь 313936,0 га, 2022 оны байдлаар 311552 толгой мянган мал тоолуулсны 13 толгой тэмээ, 57704 толгой үхэр, 28809 толгой адуу, 146275 толгой хонь, 78751 толгой ямаа байна. Тус сум нь сарлагаараа улсад тэргүүлдэг сарлагийн сүү тос болон Уянга хийцийн гэрийн эрээн модоороо улсдаа алдартай юм. Хүн амын тоогоор Өвөрхангай аймгийн 19 сумаас 3-д, газар нутгийн хэмжээгээр 9-д ордог хүн амын нягтрал 2,9 хүн/га/ сум юм. Сумын төвд 2012 онд 2 км бетонон зам тавьж эхлээд одоогоор ашиглалтанд орж, 2019 онд сумын төвийн 2 км бетонон замыг улсын төсвийн 740.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 50.0 сая төгрөгөөр засварлаж, асфатлан хүлээн авсан. 2017 иргэдийн хандиваар 0,8 км замыг засаж сайжруулсан. Аймгийн төв болон багуудтай шороон замаар холбогддог. 1990 онд Бадрал жаргалант баг нь 2012 онд Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Одоо сумын төвд 10/04 ква-ийн дэд станц 8 ширхэг, 5/04кв- ын дэдстанц 2, нийт 10 дэд станц ажиллаж байна. Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн 8 гүний худгаас түгээж байна.



Уянга сумын төв нь цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон бөгөөд цахилгаан эрчим хүчний хэрэгцээгээ Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ (ЭБЦТС)-ний эх үүсвэрээр Арвайхээр сумаас цахилгаан дамжуулах 35000 квт-ын 1 дэд станцаас 10 квт-ын 12 дэд станцаар дамжуулан хангагддаг. Бадрал, Жаргалант багийн төв нь цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон бөгөөд сумын төвөөс 10 квт-ын шугамаар 3 дэд станцаар дамжуулан хангагддаг онцлогтой.

Тус суманд “Хан-Арвай” ХХК-ын 2 уурын зуух үйл ажиллагаа явуулж дулааны эрчим хүчийг үйлдвэрлэж түгээдэг. Тус уурын зуух нь 3 төрлийн тогоотой бөгөөд 1.5NW маркийн тогоо нь 12000 м3, 9000 м3, 9000 м3 талбайг халаах хүчин чадалтай. Нийт 14 төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийг дулааны эрчим хүчээр ханган жилдээ 800 тн нүүрс хэрэглэн 1 цагт 60м/вт дулаан үйлдвэрлэдэг. Жаргалант багийн төвд “Баянцэгц” ХХК-ын 1 уурын зуух үйл ажиллагаа явуулж дулааны эрчим хүчийг үйлдвэрлэж түгээдэг. Тус уурын зуухны 18 маркийн тогоо нь 18000 м3 20 маркийн тогоо нь 10000 м3 талбайг халаах хүчин чадалтай. Нийт 4 төрийн байгууллагыг дулааны эрчим хүчээр ханган жилдээ 800 тн нүүрс хэрэглэн 1 цагт 70 м/вт дулаан үйлдвэрлэдэг.



ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн хамгийн их утга 100-100 м зайд нөлөөлөл буурах зай алгуур, түүнээс цааш нөлөөлөл бага байна. Иймд ялгаралтын хэмжээг бууруулж нөлөөллийн хамрах хүрээ, эрчмийг бууруулах нь орчны ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Дизель үүсгүүрт хүрэлцээ, хангамж сайтай болон дундаж өртгөөр худалдан авах боломжтой. Хүхрийн аль болох бага агууламжтай түлш шатахууныг хэрэглэх нь зүйтэй. Дизель үүсгүүрээс ялгарах хаягдал хийн найрлага: nox , co , So_2 зэргээс бүрддэг. Мөн нарийн ширхэгт тоос тоосонцор (pm_{10} , $\text{Pm}_{2.5}$) агаарт дэгдэх тул агаарын чанарын хяналт шинжилгээг улирал тутам улсын итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай.

Барилгын ажлын үе шатанд ямар ч тохиолдолд ажилчдын болон удирдлага захиргааны түр сууц, байрыг дулаацуулах. Ажилчдын хоол цайг бэлтгэхэд нүүрс. Мод түлэх зуухыг огт ашиглахгүй ба дизель цахилгаан үүсгүүр болон газыг ашиглана. Барилгын ажлын болон үйлдвэрлэлийн үе шатанд хог хаягдал их хэмжээгээр гарахгүй ба гарсан хог хаягдлыг зориулалтын хог хаягдлын төвлөрсөн цэгт тээвэрлэнэ.

Барилгын материалын тээвэр. Газар шорооны ажил, тэсэлгээтэй холбоотой тоосжилтыг боломжит бага түвшинд байлгах техникийн шийдлүүдийг (зам сайжруулах, тоосжилтын үед усалгаа хийх гэх мэт) ашиглах нь зүйтэй.

Барилгын ажлын үе шатанд дуу чимээ, чичирхийллээс сэргийлэх эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах бүхий л дүрэм. Стандартуудыг мөрдөж ажиллах болно. Дуу чимээ хэт ихтэй тоног төхөөрөмжүүдийг өдрийн цагаар. Давхцалгүй ажиллуулах, нэг удаад олон цагаар бус тодорхой цагуудад хуваан ажиллуулах шаардлагатай.



3.2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Хөрсөнд хаясан, асгарсан шингэн Барилгын ажлын явцад үүссэн хотгор, гүдгэр овоолго зэрэг нь гадаргын усны горимд нөлөөлөх. Ус залах далан, шороон арлыг байгуулах үеийн технологийн горим зөрчигдөх мөн чанарын шаардлага хангахгүй материал ашигласнаас үүдэн голын ус бохирдох зэрэг болно. Гол мөрнөөс усыг авч ашиглахдаа түүний экосистемийг тэтгэх урсцыг голд үлдээж голын татам болон усны амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах, бүс нутгийн усан хангамжийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх нь туйлын чухал. Усан цахилгаан станцуудын нэгэн адил төслийн барилгын ажлын болон үйлдвэрлэлийн үе шатанд гадаргуун болон гүний усны нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөлөл нь

- Голын урсацад нөлөөлөх
- Голын ус бохирдох
- Гүний уст давхаргад нөлөөлөх

Голын урсацад нөлөөлөх эсэх

Ус хуримтлуурын цахилгаан станц нь уламжлалт усан станцуудаас өөр горим ажиллагаатай байдаг. Ус хуримтлуурын цахилгаан станц нь голын голдрил, урсцыг өөрчлөн, гол дээр далан барьж, их хэмжээний талбайд усыг боон усан санг үүсгэдэггүй онцлогтой. Шууд утгаараа голын экосистемд халддаггүй.

Олон улсын туршлагад голоос ус авах хэмжээг тогтооход

- хамгийн багадаа 10 жилийн урсцын ажиглалтын мэдээлэл, жилийн тохируулгатай усан сан байгуулах тохиолдолд 25 жил,
- Олон жилийн тохируулгатай томоохон усан сан байгуулах бол багадаа 40 жилийн ажиглалтын мэдээлэлд суурилдаг байна.

Онги голын Уянга харуулын хувьд 1978 оноос хойш тасалдалтай хэмжилтүүд хийгдсэн ба 1978-2018 онуудад тасралтгүй хэмжилт хийгдсэн учир голоос ус авч ашиглах усны хэмжээг тогтооход мэдээлэл хүрэлцээтэй гэж үзэж болно. Онги голоос авч ашиглаж болох усны хэмжээг Онги голын эхэн хэсгээс 4-6 хувийг авч ашиглах боломжтой байдаг.

Онги голын Уянга харуулын олон жилийн урсцын нормоос харахад жилдээ 73 599.5 мян м3/жил ус урсан өнгөрч байна. Голоос авч ашиглаж болох экологийн урсцын хэмжээг тооцоход 4-11 сард 1070.0 мян м3/жил, 5-11 сард 22 535.3 мян м3/жил болж байгаа нь Онги-Булагт уулын УЦС-н жилд хэрэглэх 2 194.5 мян.м3 болон ногоон байгууламжид ашиглах 410 м3, унд ахуйн 283.5 м3 нийт 2 195.2 мян.м3 ус хүрэлцээтэй байна.

Усан санд татсан усыг голд буцаан сэлгэхгүй тул голын усны чанарт өөрчлөлт орохгүй. Төслийн талбай нь Онги голын энгийн хамгаалалтын бүсэд байрлах тул барилгын ажлын үед ашиглагдах машин техник, тоног төхөөрөмжийн шатах тослох материал асгарах хөрсөнд нэвчиж хөрсний ба гүний усыг бохирдуулах магадлалтай.

Төслийн үйл ажиллагаанд ямар нэгэн химийн болон цацраг идэвхт хорт элементүүд хэрэглэгдэхгүй учраас газрын доорх болон гадаргуун усанд бохирдол үүсэх эрсдэл бага байна. Дээд усан сангийн ус доош шүүрэн алдагдагдсан тохиолдолд уулын ул хөрсний болон уулын чулуулгийн гулсалт үүсэх аюултай үзэгдэл явагдаж болзошгүй.



3.3. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаа эхэлснээр:

- Станцын барилга байгууламж барих ажлын явцад хурдас чулуулгийн овоолго үүсэх, хурдас чулуулагт хөрс дарагдах, үржил шимт хөрсний хуулалт, овоолгоос болон төслийн талбайд хийгдэх газар шорооны ажлаас үүссэн тоос, шороо салхиар зөөгдөн төслийн талбайн ойр орчмын хөрсний шинж чанарт нөлөөлж болзошгүй.
- Станцын барилга байгууламжуудыг барихад хуулагдах хөрсний хэмжээг нарийвчлан гаргасан байна. Нийтдээ 10.1 га талбайд газар шорооны ажил, хөрс хуулалт хийхээс хамгийн том нь доод болон дээд усангийн талбайн ажлууд болно.

3.4. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Ус хуримтлуурын цахилгаан станц барих эрчимтэй үйл ажиллагааны улмаас ургамлан нөмрөг хүчтэй нөлөөлөлд ихээр өртөж. Нийт 10.1 га талбайн ургамлан нөмрөг дотоод замуудын ашиглалт, барилга байгууламжууд барих өнгөн хөрс болон хаягдал чулуулаг, ус зайлуулах суваг зэргийг барьж байгуулах, ашиглахтай холбоотойгоор дарагдах, арчигдах зэргээр үгүй болно.

Түүнээс гадна уг төслийн үйл ажиллагааны улмаас ургамлын зүйлийн бодгалиуд төдийлөн устаж алга болохгүй боловч тоосжилт, их дуу чимээ зэрэг хүний үйл ажиллагааны нөлөөгөөр үлдсэн 107.93 га талбайн ургамлан нөмрөг тодорхой хэмжээгээр талхагдалд өртөнө гэхдээ ургамлын бүлгэмдлүүд тухайн бүс нутгаа төлөөлөн байж чадахуйц хэвээр байна гэж тооцов.

Тоосжилтоос үүсэх дам нөлөө. Ус хуримтлуурын цахилгаан станц барих бүтээн байгуулалтын явцад тээвэрлэлт зэргээс үүссэн тоосжилт нь төслийн талбай орчимд буюу түүний зонхилох салхины доор орших зэргэлдээх талбайн ургамлан нөмрөгт шууд байдлаар нөлөөлөхөөсөө илүүтэйгээр дам байдлаар нөлөөлөл үзүүлнэ. Салхины доод талын хэсгүүдийн ургамлын навчны илтсүүдэд тоос ихээр хуримтлагдаж фотосинтезийн үйл ажиллагааг сааруулах нөлөөтэй.

Төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бүтээн байгуулалтын болон ашиглалтын үед гэж 2 хувааж үзэх бөгөөд бүтээн байгуулалтын үед усны барилга байгууламж барих барилгын бүхий л ажлыг ойлгоно. Ашиглалтын явцад цахилгаан станцын үйл ажиллагаа, ажиллах хүчний нөлөөлөл, 9 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугамын болон замын сүлжээнээс үзүүлэх нөлөөллийг хамруулж үзнэ. Төслийн нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ, нөлөөллийн цар хүрээ, эрчмийг арга зүйн дагуу бүрэн тодорхойлоогүй бөгөөд зөвхөн усан сан үүсэх талбайн урт нь ойролцоогоор 4,5 км, өргөн нь 7,67 орчим км, газрын гадаргын хэв шинж, өндөршлөөс хамаарч өргөн нь харилцан адилгүй байх бөгөөд нийт талбайн хэмжээ 34,55 км.кв байна. Ийм хэмжээний усан сан үүсэх, цаашид барилга, байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явагдсанаар амьтны аймагт дараах эерэг, сөрөг нөлөөллийг үзүүлж болно.



Ус хуримтлуурын цахилгаан станц барих төсөл нь голын голдрил, урсацад нөлөө багатай. Төслийн талбайн хэмжээ бага боловч Онги голын хөндийд байрлаж байгаа нь амьтны нүүдэл шилжилт хөдөлгөөнд дараах байдлаар нөлөө үзүүлэх боломжтой байна. Үүнд:

- Хуримтлуурын цахилгаан станцын зам болон барилгын ажил хийгдэх явцад энэ орчимд байгаа амьтны амьдрах орчин өөрчлөгдөх, үхэж үрэгдэх, дайжих зэрэг хүний үйл ажиллагаатай холбогдсон шууд болон дам нөлөөлөл тодорхой хэмжээгээр гарах
- Төв замаас ус хуримтлуурын станц хүртэлх замын ул шорооны далангийн байгууламж байгуулах, дүүргэх материалын орд нээж ашиглалт явуулах, усны барилга байгууламжийн ажил, материал ачих зөөх, буулгах болон машин техникийн хөдөлгөөнөөр үржил шимт хөрс ургамлын хамт зайлуулагдаж хөрсний эвдрэл үүсэх, бохирдох, шороон хучдас үе үүсэх, ургамлан нөмрөг талхлагдах, улмаар тэр хэсгийн байгалийн тэнцвэр алдагдан амьтад нэн ялангуяа хөрсний бичил амьтдад үзүүлэх нөлөө ихсэх талтай
- Хавар намрын үед хуурайшилттай нөхцөлд гал түймэр гарах нь ан амьтан үхэж үрэгдэх, дайжих явдлыг улам нх болгож дам байдлаар нөлөөлж болно
- Сонирхох болон тохиолдлын байдлаар ан амьтан барих, агнах, түүнд ховор, ховордсон зүйлүүд өртөгдөх магадлал өсөх:
- Машин техникийн хурд ихэссэнээс замын дагуу амьдрах махчин шувууд (сар бүргэд мэт) ба туулай хярс мануул мэт хөхтөн амьтад машинд дайрагдах явдал гарахад хүргэх:
- Төсөл хэрэгжих голын эрэг орчимд голдрил ихэссэн, голын ёроол ухагдаж гүнзгийрсэн, гүний уснаас сэлбэгддэг зэрэг хүчин зүйлс нь загас өвөлжих боломж бүрдвэл өвлийн улиралд гүний усанд нөлөө үзүүлвэл загас олноор үхэх:
- Ус хуримтлуурын цахилгаан станцаас төвийн шугаманд холбох агаарын шугаманд нүүдлийн болон суурин шувуу цахилгаанд цохиулж үхэлд хүрэх
- Шувуудаас нэн ховор зүйлүүд нь тэмдэглэгдээгүй бөгөөд магадгүй усан сан үүссэн тохиолдолд түүгээр дамжин өнгөрөх, түр амрах байршил нутаг болно.
- Мөн Онги голын сав газарт суурин статустай ховор, нэн ховор зүйл шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид бүртгэгдээгүй байна.
- Усны шувуудын хувьд усан цогцолборын хүрээнд үүсэх усан сан нь эерэг нөлөөтэй. Жишээ нь усан сангийн хэмжээнд хуримтлагдах идэш тэжээлийн нөөц, нүүдлийн үедээ дамжин өнгөрөх, амрах гэх мэт.
- Энэ бүс нутагт 3 зүйл загас тархах бөгөөд усан цахилгаан станцын барилгыг барихдаа загас өнгөрүүлэх зориулалтын сувагтай хийснээр сөрөг нөлөөллийг бууруулна.



ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (бомт)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Өвөрхангай аймгийн уянга сумын нутагт хэрэгжих усан цахилгаан станц төслийн 2024- 2028 он хүртэлх 5 жилийн бомт-г боаж-ийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн а/618 тоот тушаалаар батлагдсан “байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, мөн бонх-ийн /хуучин нэрээр/ сайдын 2014 оны а-117 тоот тушаалаар батлагдсан үнэлгээ хийх аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн а/618 тоот тушаалын хавсралт байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн байгаль орчны газар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаарх мэдээллийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд оруулж, хүлээн авсан тухайгаа төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим шууданд ажлын 5 хоногт багтаан хариу мэдэгдэнэ.

Ажлын хэсэг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэх ажлыг 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулж, зөвхөн батлагдсан төлөвлөгөөнд тусгасан ажлуудын гүйцэтгэлд үндэслэн төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байлцуулан, энэхүү журмын 4-р хавсралтад заасны дагуу арга хэмжээний чиглэл тус бүрээр оноогоор тооцож, биелэлтийг нь нэгтгэн гаргаж, газар дээр нь баталгаажуулан гарын үсэг зурж, төсөл хэрэгжүүлэгчид 1 хувийг хадгалуулна.

Төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 90 оноо хүрээгүй буюу, хангалтгүй гэж дүгнэгдсэн бол хангалтгүй хийгдсэн ажлыг дараа оны эхний улиралд багтаан гүйцэтгэсэн тохиолдолд дүгнэлтийг дахин гаргуулна. Тухайн жилийн



байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн бол үүнд хамаарахгүй.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.



ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай. Байгалийн нөөцүүд тус бүрээр нь ангилан авч үзлээ.

5.1. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

1. Тоног төхөөрөмжийг сонгохдоо шатахуун зарцуулалт хамгийн бага байх нөхцөлийг харгалзан сонгох
2. Хүхрийн аль болох бага агууламжтай түлш шатахууныг хэрэглэх нь зүйтэй
3. Тээврийн хэрэгсэл бүрийг техникийн улсын үзлэгт тогтмол хамруулж байх
4. Зам сайжруулж, тоосжилтын үед усалгаа хий, машины хурдыг хязгаар тогтоох
5. Барилгын ажилчдыг ая тухтай амрах нөхцөлийг хангах үүднээс түр сууцыг хол зайд барих, дуу чимээ ихтэй ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх
6. Ногоон байгууламжийн төлөвлөлт оновчтой зохион байгуулах, ажилчдад нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болох чихэвч, дуу намсгагч байнга зүүлгэх



Хүснэгт 2.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын бохирдол үүсэх	Газар шорооны ажлыг төлөвлөсөн талбайд явуулж, эрүүл газрын хөрсийг эвдрэлд оруулахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, олон салаа зам гаргахгүй байх	Төслийн талбайд	Үйл ажиллагааны хүрээнд				Төсөл хэрэгжих хугацаанд	Агаарын бохирдуулсны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016 MNS4585:20I6 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2		Хуурайшилт ихтэй үед зам талбайг услах		Тухай бүрт		100.0	100.0		
3	Шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг унтрааж байх	Үйл ажиллагааны хүрээнд							
4	Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хортхий ялгарах	Барилгын материалыг тээвэрлэх ачих буулгах үед тоосжилт үүсэхээс хамгаалах (салхи багатай үед ачиж буулгах, барилгын материалыг хучих г.м)		удаа	1	600.0	600.0		
5		Тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэгт оруулж, ялгаруулж буй хорт хийн түвшинд хяналт тавих. засвар үйлчилгээг тогтмол хийх		Үйл ажиллагааны хүрээнд					
6		Барилгын газар шорооны ажил, тээвэрлэлт үед тоос ихээр дэгдэх		Үйл ажиллагааны хүрээнд					
Нийт дүн							700.0		



5.2. УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

1. “Усны тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 33 дугаар зүйлийн 3 дахь заалтын дагуу усыг хэмнэлттэй ашиглах технологи нэвтрүүлэх, бохир ус цэвэрлэх технологийн горимыг мөрдүүлэх үүрэг бүхий усны хэрэглээ хариуцсан менежертэй байх;
2. Гадаргын ба газрын доорх усны горимын ажиглалтыг тогтмол хийж тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж байх;
3. Газрын доорх усны судалгаа, мониторинг хийх;
4. Усны эх үүсвэр дээр суурилуулсан баталгаажуулсан тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг төлж барагдуулж байх
5. Ундны усны чанар найрлаганд тогтмол хяналт тавих, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгүүлэх
6. “Усны экологи эдийн засгийн үнэлгээг батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 тоот тогтоолоор Онги сав газарт тогтоосон усны экологи эдийн засгийн суурь үнэлгээгээр, 2013 оны 326, 327-р тогтоолоор ашиглалтын зориулалтын итгэлцүүр, хувь хэмжээгээр усны нөөц ашигласны төлбөрийг тогтоож, тогтоосон хэмжээгээр Төсвийн тухай хуулийн 23.8.9-д заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.
7. Онги голын ус зүйн сүлжээ, гадаргын болон газрын доорх усны өнөөгийн төлөв байдал, ирээдүйн хандлагыг тодорхойлох;
8. Голын экосистемд сөрөг нөлөөгүй байдлаар төслийг хэрэгжүүлэх шинжлэх ухааны үндэслэл бүхий аргазүйд тулгуурлан судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх;
9. Төслийн усан сан дүүрэн үйл ажиллагаа жигдрэн УЦС-аас доош ус гарч эхэлсэнтэй холбоотойгоор далангаас доошхи голууд тэжээгдэж эхэлснээр үзүүлэх сөрөг нөлөөлөөл багасах арга хэмжээг судлах;
10. ОХШХ-т тусгасны дагуу голын усны өнгөрөлтөнд хэд хэдэн цэгүүд дээр мониторинг хийн судалгаа явуулах;
11. Ус хурах талбайн хэмжээнд аливаа үйл ажиллагаа явуулахдаа нарийвчлан төлөвлөн гүйцэтгэх, шаардлагатай үед нь зохих арга хэмжээ авч байх ёстой.
12. Нуурын усны урсгал бага тогтуун хэсэгт усны найрлагыг тодорхойлох шинжилгээ хийлгэн давслагийн хэмжээг тодорхойлж байх;
13. Голын мөсний үзэгдэл, зам гүүр, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг бодитойгоор судлах, хяналт тавих;
14. Усан сангийн усны зарцуулгын тооцоо хийх судалгааны ажлыг тогтмолжуулах усны харуулын мэдээлэлийн бага оврын станцтай болгох
15. Хур борооны ус зайлуулах үерийн далан хамгаалалтын суваг шуудууг байгуулснаар болзошгүй байгалийн гамшигт үзэгдэл үер усны аюулаас эд хөрөнгө, түүнчлэн хүний амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллах;
16. Боомтын барилгын ажлын үед голын сав газрыг барилгын материалаар бохирдуулахгүй байхад анхаарч, урьдчилан хамгаалах арга хэмжээ авсан байх;



17. Цэвэрлэх байгууламжаас гарч буй ус нь MNS 4943:2011. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд байнга хяналт тавьж ажиллах;
18. Хатуу шингэн хаягдлыг графیکیн дагуу сум орон нутгийн зөвшөөрөл бүхий хогийн цэгт тээвэрлэн зайлуулах;
19. УЦС-ын доод хашицад усны урсгалын хурдыг бууруулах, загасны үржил, шилжилт хөдөлгөөнд үзүүлэх нөлөөллийг арилгах технологийн арга хэмжээ авах;
20. Усан сангийн тохируулгаар боомтоос дооших усны горимыг зохицуулж, үерийн улмаас учрах хохирлыг бууруулах боломж байгаа эсэхийг тооцоолон судлах, хэрэгжүүлэх;
21. Шинээр буй болох нуурын усны экосистемийн шинж төлөв, хөгжилт, нөлөөллийг судлах;
22. Болзошгүй их үер, үерлэх үеийн боомтын тогтворжилтод үнэлгээ өгөх, аюул тулгарах үед эрсдлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, аюулгүй байдлыг хангах;
23. УЦС-ын доод хэсгийн Онги голын дагуу болон усан сангийн эргийн орчныг бургасжуулах, загас, ёроолын амьтдын судалгаанд үндэслэн хамгаалах чиглэлээр байгаль орчны хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
24. Нуурын эрэг дагуу Усны тухай хуулийн 22-р зүйлийн 22.2, 22.3-р заалтын дагуу хамгаалалтын бүс байгуулж, холбогдох дүрэм журмыг биелүүлж ажиллах, эрэг орчмыг байнга цэвэрлэж байх;
25. ОХШХ-т тусгасны дагуу голын усны өнгөрөлтөнд хэд хэдэн цэгүүд дээр мониторинг хийж судалгаа явуулах;
26. Нуурын усны урсгал бага тогтуун хэсэгт усны найрлагыг тодорхойлох;
27. Газрын доорх усны чанар, бохирдлын түвшинг хянаж байх;
28. Газрын доорх усны хяналтын цооног өрөмдөж судалгаанд зориулж тоноглох;
29. Гидрогеологийн хяналтын цооногуудад газрын доорх усны түвшинг ус хуримтлуулж усан сан байгуулах явцад сард 4 удаа хэмжиж, үр дүнг тусгай журналд тэмдэглэн усны чанар, түвшний өөрчлөлтийн талаар боловсруулалт хийж дүгнэлт гаргаж байх;
30. Хур тунадас их хэмжээгээр орсон тохиолдолд /дулааны улиралд/ газрын доорх усны түвшний өөрчлөлтийн хэмжилтийн давтамжийн хугацааг ойртуулж, тогтмол хэмжиж журналд тэмдэглэх;
31. Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх бөгөөд ус ашиглах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглох;
32. Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх, 30 дугаар зүйлийн 30.1, 30.6 дахь хэсгийг хэрэгжүүлж ажиллана.



Хүснэгт 3.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Усан орчин бохирдох	Ахуйн хатуу хаягдлыг ангилан хадгалах, ил задгай хаяхгүй байх, богино хугацаанд нутаг дэвсгэрээс сумын хогийн цэг рүү гэрээний дагуу зайлуулах	Төслийн талбай	Гэрээний үнийн дүн				Төсөл хэрэгжих явцад	“Усны тухай хууль” БОАЖСайд, БХБСайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаал
2		Тээврийн хэрэгслүүдийн шатах тослох материалын хэрэглээ болон тэдгээрийн хаягдалд хяналт тавьж, зохих журмыг баримталж ажиллах		Ү/а-ны зардал					
3		Ажиллагсдын тосгонд бага оврын цэвэрлэх байгууламж байгуулж ашиглах		Ү/а-ны зардал					
4	Усны горим, чанарыг хамгаалах	Барилгын ажил үргэлжлэх хугацаанд голын (онцгой ба энгийн) хамгаалалтын бүсийг тогтоож, хамгаалах арга хэмжээ авах	Онги гол	удаа	500.0	1	500.0	2024	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль MNS 6561:2015 MNS 4943:2015 MNS 6734:2018
5		Голын барилгын ажил явагдах хэсэг дээр лаг шаврын хуримтлал үүсэх, барилгын материалын хог хаягдлаар бохирдож болзошгүй тул хамгаалах хашлага /silt fencing/ хийж хаягдлыг ус руу орохоос хамгаалах /2 хэсэг/	Онги гол	удаа	300.0	1	300.0	2024	
6		Түр урсацаар зөөвөрлөгдөн ирж хуримтлагдах хагшаас болоод хогийг цэвэрлэн зөөж зайлуулах ажлыг тогтмол хийж байх;	Төслийн талбай	Тогм тол	100.0	Тогт мол	100.0	Төслийн хуацаанд	
7	Усны нөөц чанар, горимд өөрчлөлт орох	Усны химийн найрлага, чанарын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	голын ус	Гэрээний үнийн дүн					
8		УЦС-ын усан сангийн мониторингийн цэгүүдэд байнга хэмжих усны автомат түвшин хэмжигч суурилуулах	Голын ус	Үйл аиллагааны хүрээнд					
9		Онги голын онцгой ба энгийн хамгаалалтын бүсэд таних тэмдэг, анхааруулах самбар байрлуулах	Онги гол эрэг орчим	удаа	250.0	2	500.0		
10		Усны нөөц ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөх	Ус ашиглалт	Үйл ажиллагааны хүрээнд					
Нийт зардал							1400.0		



5.3. ХӨРСӨН БҮРХЭВЧ, ГАЗРЫН ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн үйл ажиллагаанаас эвдрэлд өртөх талбай 7.5 га байна. Иймээс хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл дундаас их түвшинд байгаа тул бүтээгдэхүүн тээвэрлэлт болон бусад дагалдах үйл ажиллагааны улмаас газар, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээг дараах байдлаар төлөвлөн хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

1. Бүтээгдэхүүнийг зориулалтын бус замаар тээвэрлэх явдлыг бүрэн хориглох;
2. Түлш, шатах тослох материал асгарах, хаягдахаас сэргийлэх;
3. Шимт хөрсний хуулалт, хадгалалтыг стандартын дагуу хийж гүйцэтгэх;
4. Газар ашиглалтад хяналт тавих,
5. Хөрсний бохирдлын болон эрүүл ахуйн мониторинг тогтмол хийлгэж байх;
6. Барилгын бүтээн байгуулалтын ажил дууссаны дараа техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зохих стандартын дагуу хийж гүйцэтгэх гүйцэтгэх;
7. Шатах тослох материал хадгалах, засвар хийх талбайг үер, галын аюулд өртөхөөргүй газарт сонгон байрлуулж, санамсаргүй тохиолдлоор асгарахаас урьдчилан сэргийлж элс хайрган хучилт хийж, тусгай тэмдэг тэмдэглэгээг байрлуулах.
8. Нефтийн бүтээгдэхүүн нь органик нэгдлүүдийн нийлмэл бөгөөд хөрсөнд нэвчсэн тохиолдолд түүний гүнд ихээхэн хэмжээний бохирдлыг бий болгон удаан хугацаагаар хадгалагддаг онцлогтой. Ингэж бохирдсон хөрсийг хуулан авч тусгаарлагч гадаргуу дээр овоолон 18-20%-ийн хлораминий уусмалаар бороожуулан ариутгаж эсхүл бууц хольж асган саармагжуулж болно.
9. Барилгын ажлын үед тээврийн хэрэгсэл, машин механизмын зорчих замыг тэмдэгжүүлж, машин техникийн зогсоол, шороон замын хөдөлгөөнд хяналт тавьж, олон салаа зам гаргаж, хөрсөн бүрхэвчийг эвдэхээс хамгаалах, хяналт тавих,
10. Авто машины тусгай зориулалттай зогсоолтой байх
11. УЦС-ын ажлын талбай, зам дагуу түүний ашиглалтад хяналт тавьж, зам талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийх
12. Байгалийн хуурайшил дулаарал, үер усны угаагдлаар гулсалт нуралт явагдаж буй газруудыг олж тогтоон хөрс бэхжүүлэх, эвдэрлийг сааруулах арга хэмжээ авч байх;
13. Нуурын эрэг дагуу түүний орчмын зарим хөрсний ус дээр, усны урсгал бага хотосдуу хэсгүүдээр намагших, давсжих үйл явцыг хянах;
14. Усан цахилгаан станцын ойр орчмын хөрсийг ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдал болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх



Хүснэгт 4.

Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Барилгын үйл ажиллагаанд өртөх талбайн шимт хөрсийг хуулах, талбай бэлтгэхэд хорсон бүрхэвч эвдэрнэ	Газар чөлөөлөх талбай бэлтгэх үед хөрсийг хуулж тусгайлсан газарт (ахин зөөхгүй, үерт урсахгүй) овоолго үүсгэн хадгалах	Төслийн талбай	-	200.0	1	200.0	Төсөл хэрэгжих явцад	MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис,элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо тодорхойлолт, Газрын тухай хууль,
2		Төслийн төлөвлөлтийн ажлын үед хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах	Хог хаягдал	удаа	300.0	1	300.0		
3		Боомтын барилга байгууламжийн ажил явагдаж буй талбайн хэмжээнд үерийн хамгаалалтын далан болоод голын урсацыг зайлуулан урсах түр шороон суваг шуудуу, туннель, үржил шимт хөрс ба хурдсын овоолго, бусад зориулалтаар түр ухагдсан газрууд зэргийг оролцуулан талбайн хэмжээнд хөрсний элэгдлийн хяналт судалгааг идэвхтэй явуулж, тухай бүр нь засч бэхжүүлэх, хамгаалалтын арга хэмжээнүүд авч байх;	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардал					
4	Бүтээн байгуулалтын үйл ажиллагааны нэгж бүр дээр тавих байгаль орчны хяналтыг тогтмолжуулж, гарч буй зөрчлийг тухай бүр нь арилгаж, зам талбайг эвдрэл гэмтэлгүй, хоггүй хэвийн ашиглалттай байлгахад анхаарч ажиллах;	удаа		300.0	1	300.0			
5	Хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд орох, бохирдол	Хөрсний нурулт гулсалтаас хамгаалах, хөрс бэхжүүлэх арга хэмжээ авсан байх;	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардал					
6		Үйлдвэрлэлийн ажиллагаанд байнгын хяналт тавьж, талбайг цууралт, эвдрэл гэмтэлгүй байлгах засвар арчлалт, сайжруулалт, гарсан бохирдлыг цэвэрлэх ажлыг тухай бүр нь хийж байх;		Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан					
7		Хөрсөн орчны мониторинг судалгааг хийх	Төслийн талбай	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан					
	Нийт зардал		800.0						



5.4 УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

1. Төслийн үйл ажиллагааг ТЭЗҮ-д заасны дагуу хийж, илүү газар эвдэхээс зайлсхийх, олон салаа зам үүсэхгүй байх;
2. Шимт хөрсний овоолгыг элэгдэл хорогдлоос хамгаалах, мөн хөрсний микро организмын амьдралыг тэтгэх үүднээс шаардлагатай нөхцөлд ургамалжуулах арга хэмжээ авсан байх
3. Тоосжилтыг бууруулах, шаардлагатай үед дотоод тээврийн замыг услах арга хэмжээ авах
4. Төслийн ашиглалтын хугацаа урт учраас ажиллагсдын кемпийн орчинд ногоон байгууламж байгуулах арга хэмжээг авах,
5. Шимт хөрсний агуулахад орон нутагт тархацтай ховор, ховордуу ургамал, буурцагт ургамлыг ургуулах, орон нутгийн ургамлын үрийн цуглуулга хийж, нөхөн сэргээлтэд ашиглах, Мөн нөхөн сэргээлтийн туршилтын талбай байгуулах
6. Загас, усны амьтан ургамлын амьдралын хэвийн нөхцөл, нүүдэл шилжилт хөдөлгөөн, үржил хөгжлийг алдагдуулахгүй байх, хамгаалах талаар урьдчилж гаргасан зураг төлөвлөлтийн дагуу арга хэмжээ авах
7. Хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад онцгой анхаарч ажиллах.



Хүснэгт 5

Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	Ургамалан нөмрөгийг талхагдлаас хамгаалах	Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах	Төслийн талбай	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд зардал тусгагдсан				Төсөл хэрэгжих хугацаанд	Нөхөн сэргээлтийн Аргачлал Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай MNS 4585:2016	
2		Барилга байгууламжуудыг барьж дууссаны дараагаар эвдэрсэн талбайг үржил шимт хөрсөөр хучин байгалийн аясаар нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх		Иж бүрэн	560.0	1	560.0			
3		Мод тарих	Гол дагуу	Үйл ажиллагааны зардал						
4	Амьтаны аймаг хамгаалах	Хууль бус антай тэмцэх (ажилчдад хулгайн ан хийхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журмын талаарх танилцуулах ухуулах самбар, тэмдэглэгээ байршуулах)	Төслийн талбай	ширхэг	200.0	1	200.0			Амьтны тухай хууль Ан агнуурын тухай хууль
5		Биологийн төрөл зүйлийн судалгаа, мониторингийг хэрэгжүүлэх	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардал						
6	Загасны үржил хөгжил, нүүдэл шилжих хөдөлгөөн хумигдах	Ус өнгөрүүлэх суваг- шуудуу, туннелийн усны уналтын хүч, асс, урсгалын хурдыг загасны нүүдэл, биологийн онцлогт тохируулан шийдвэрлэх, мэргэжлийн түвшинд хяналтыг тогтмолжуулж ажиллах;	Голын ус	Үйл ажиллагааны зардал						
7	Хөхтөн амьтад болон загас, мөлхөгчид, усны хөвөгч ба ёроолын амьтдын хувьд нүүдэллэн шилжих талбай нь хуваагдаж буурах	Усан сан байгуулах үед хавцлаас доошхи голын хэсгийн усны түвшин, урсацын байдалд тогтмол хяналт тавьж ажиллах /Усны харуул 1- ийг байгуулах/,	Усан сан	удаа	400.0	1	400.0			
		Тээврийн зам дээр мал, амьтан өнгөрөх гарц гаргах, саадгүй нэвтрэх боломжийг бий болгох, жолоочид анхааруулсан тэмдэг тэмдэглэгээ хийх	Төслийн талбай	ширхэг	200.0	1	200.0			
		Амьтдад хэрхэн нөлөөлж буйг маршрутын судалгаагаар тогтоох								
Нийт зардал								1360.0		



5.5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад амрагч ажилчдын ахуйн хог хаягдал болон ариутгал халдваргүйтэлийн химийн бодисын, урвалжийн савны хаягдал үүснэ. Ахуйн хаягдлыг түр хогийн цэгт хуримтлуулж улмаар зориулалтын автомашинаар тээвэрлэн орон нутгийн төвлөрсөн хогийн цэгт хүргүүлнэ. Цаашид дахин ашиглах боломжтой хаягдлыг аль болох дахин ашиглах хувь хүн, байгууллагуудад нийлүүлж хог хаягдлын хэмжээг бууруулж ажиллах хэрэгтэй.

Хүснэгт 6.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая. төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
1.	Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах, хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байна.	Хог хаягдлын цэг	Иж бүрэн	500.0	1 удаа	500.0	2024	Хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
2	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэгт 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал				Төслийн хугацаанд	Засгийн газрын А/349 тогтоол Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт
3	Хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хүнсний хаягдлыг усгүйжүүлж органик компост бордоо болгон зүлэг, мод арчилгаанд ашиглах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал					
4	Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг“MNS 5161-3:2002, Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлд. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ стандартын дагуу мэргэжлийн газраар гүйцэтгүүлэх.	Хог хаягдлын цэг	Тогтмол	50.0	улиралд	200.0		
5	Шингэн хог хаягдал хадгалах зориулалтын цэгтэй болох	Шингэн хаягдал	Үйл ажиллагааны зардал					
6	Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах, орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хог устгалын цэгт хүргэх	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал					
7	Хог хаягдал хадгалах зориулалтын цэгийг байр сууц, хоолны газраас 50 м- с багагүй зайд бие засах газраас тусад нь, зонхилох салхины доод зүгт байрлуулж, салхинд хийсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн, хөрсөнд шингээлт үүсэхээс хамгаалсан байх.	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал					
8	Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх	Төслөөс үүсэх хог хаягдал	Үйл ажиллагааны зардал					БОАЖ-ын сайдын А/445 тогтоол Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар БОАЖ, Сангийн сайдын 192, А/243 хамтарсан тушаал Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЯНГА СУМЫН НУТАГТ БАРИГДАХ “3 МВТ-ЫН ХҮЧИН ЧАДАЛТАЙ УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

9	Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах	Төслөөс үүсэх хог хаягдал	Гэрээний үнийн дүнгээр				Төслийн хугацаанд
10	Хог хаягдлыг зориулалтын цэгээс нэгдсэн хогийн цэгт тээвэрлэхэд MNS 5344:2003, Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал. Ерөнхий шаардлага” стандартыг баримтлах.	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал				
11	Асгарсан шатах тослох материал ба барилга үйлдэрлэлийн хатуу шингэн бодис материалыг цэвэрлэх	Төслийн талбайд	шир хэг	1	100,0	100,0	
12	Барилгын ажлын талбай, ажлын ба туслах зам, чулууны үйлдвэр, бетон завод, ган ба модны үйлдвэр, материалын ил агуулахууд, түр суурин, тэдгээрийн нөлөөллийн бүсэд хог хаягдал цэвэрлэж зайлуулах ажлыг тогтмол явуулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал				
Нийт зардал					800.0		



5.6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх;
- Ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрч болзошгүй тул төсөл хэрэгжүүлэх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх;
- Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн олон нийтийн байгууллага, шуа-ын археологийн хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө. Энэ төлөвлөгөө, хөтөлбөрийг төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөж мөрдөх

Хүснэгт 7.

Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Уг эзэмшлийн газраас 12 дурсгалт зүйл илэрсэн бөгөөд тэдгээрийг дотор нь ангилбал хүрлийн үеийн хиргисүүрийн дурсгал 4, чулуун дараастай дөрвөлжин булш 8 тус тус олдсон.	Үйл ажиллагаа явуулахаас өмнө археологийн мэргэжлийн байгууллагаар дээр дурдсан түүх, соёлын дурсгалуудыг арванхамгаалах малтлага хийлгэж, дурсгалуудыг зөөвөрлөн газрын чөлөөлөх шаардлагатай	Төсөл Хэрэгжүүлэх нийт талбайн хэмжээнд	Гэрээний үнэн дүнгээр	2024-2025 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/,
Төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд Гарч ирж болзошгүй.	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.		Тухайн үед нь шийдэх	Үйл ажиллагааны турш	Бусад холбогдох Салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд



5.7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд олборлосон элсийг уурхайн талбайд скруберээр баяжуулна. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер, техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 8.

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн Зардал (мян.төг)	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх Хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгалийн аюул гамшиг							
Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшиг үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах	Төслийн талбайн ойр орчимд	1	80.0	80.0	2024-2028	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003- (сүүлийн нэмэлт өөрчлөлт (2012.05.17))
	Аянга хамгаалагч ба газардуулга суурилуулах (аянга газардуулагчийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү сайтаас авах www.achhold-ing.mn)	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024	
	Эдэлбэр газар үер, газар хөдлөлт, аянга, галын аюулгүй байдлыг хангасан хамгаалалттай, болзошгүй ослын үед ашиглах заавар, схем зургийг нүдэнд харагдахуйц газар ил байрлуулах.					2024-2028	
	Байгалийн аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах талаар 1 жилд 1 удаа мэргэжлийн байгууллагатай хамтран сургалтыг зохион байгуулах		1	200.0	200.0	2024-2028	
	Хөрсний гулсалт, нуралт гарч болзошгүй газруудад түүнээс хамгаалах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024-2028	
	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгүүлэх		Гэрээний үнэн			2025	



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЯНГА СУМЫН НУТАГТ БАРИГДАХ “3 МВТ-ЫН ХҮЧИН ЧАДАЛТАЙ УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

			дүнгээр				
Нийт				280.0			
Галын аюул							
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох хөөс, хорны суурь, тэмдэг тэмдэглээ, сарай, элсний хайрцаг, шланг зэргийг бэлэн байлгах.	Галын аюул эрсдэл	1	500.0	500.0	2024-2028	MNS 5390:2004, ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага Галын аюулгүй байдлын тухай хууль, MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах, аж ахуйн нэгж байгууллага,
	Түймрийн хамгааллын хэрэгсэл багаж тоног төхөөрөмжөөр хангах (Үлээгч аппарат, цуравдагч, түймрийн хүрз, жоотуу, цохиур гар хөрөө лоом, хүрз, сүх, хөрөө, хувин,	Галын аюул эрсдэл	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024-2028	
	Нийт				500.0		
Хүний аюулгүй байдал, эрүүл мэнд, тав тух алдагдах							
Барилгын ажлын үед гарч болзошгүй ХХАА-ны зөрчил	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024-2028	MNS 6043:2019 MNS 4934:2002 MNS 5824:2009 MNS 5409:2004 MNS 4946:2005 MNS 5231:2003 MNS 4597:2014 MNS 5342:2007 MNS 5344:2011 MNS 6426-2013
	Анхны тусламж болон яаралтай тусламж үзүүлэх нөхцөлөөр хангагдсан багаж хэрэгсэл, эмийн сан байршуулах.		1	200.0	200.0		
	Төслийн бүх ажилчдад өдөр бүр ажил эхлэхээс өмнө ХХАА-ны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХХАА-ны зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг тухайн өдөрт ажиллахыг хориглох		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан				
	Бүх техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих, газардуулга хийх						
Нийт зардал					200.0		
Нийт дүн					980.0		



5.8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Газар чөлөөлж нүүлгэн суурьшуулах асуудлаар Монгол Улсын хууль тогтоомжид төлөвлөгөө хийхийг шаарддаггүй, харин Дэлхийн Банкны ҮАБ/ББ 4.12-ын шаардлагад нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, ядаж л хамгийн багаар нүүлгэн суурьшуулах хувилбарыг санал болгохыг заасан байдаг. Шилжүүлэн суурьшуулах үйл ажиллагааг зохих бэлтгэлийг нарийн сайн хангаж, маргаан үүсэхээс зайлсхийх нөхцөлийг бүрдүүлж дуусгасны дараа төлөвлөгөөнд тусгасан дэс дарааллын дагуу хэрэгжүүлж эхэлнэ.

Хүснэгт 9.

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Шилжүүлэн суурьшуулах үйл ажиллагааны бэлтгэл	Нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох	Нөлөөллийн бүсийн айл өрх	7 айл өрх	10 000.0	10 000.0	2024-2029 он	Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоол Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам
	Нөлөөлөлд өртөгчдийн бүртгэл, тасалбар болгох, баталгаажуулах						
	Нөхөн олговор авах эрх, нөхөн олговрын төрөл						
	Нөхөн олговрын үнэлгээ						
	Нөхөн олговрын үнэлгээний тайлан, түүнийг баталгаажуулах						
	Шинэ суурьшил						
	Үйл ажиллагааны зардал						
Нийт зардал мян.төг					10000.0		



5.9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тухайн төслийг хэрэгжүүлсэнээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

Хүснэгт 10.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян. төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7
Агаарын чанарын шинжилгээ							
1.	Агаарын чанарын хяналт, CO2, NO2, SO2 Тоос нийт (PM10, PM2.5)	Далангийн ойролцоо-1 цэг Станц барилга хажууд-1 цэг	Жилд 1 удаа	2 цэг	50.0	100.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2019 Агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ.
	Дуу шуугиан	Барилгажих талбай-1 Далангийн ойролцоо-1		2 цэг	50.0	100.0	MNS 6768 : 2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага
	Агаарын чанарын шинжилгээний нийт зардал					200.0	
Газрын доорх ус							
2.	Мониторингийн цооногууд өрөмдөн газрын доорх усны чанарыг хянах	Тохиромжтой 4 цэгт	Жилд 4 удаа	4 цэгт	48.0	768.0	MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч
	Мониторингийн цооногууд			Түвшний хяналтын бүртгэл			



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЯНГА СУМЫН НУТАГТ БАРИГДАХ “3 МВТ-ЫН ХҮЧИН ЧАДАЛТАЙ УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	өрөмдөн газрын доорх усны хөдөлгөөний горим, усны чанарыг хянах		Сард 1 удаа			бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
Нийт					768.0		
Гадаргын ус, усны чанарын шинжилгээ							
3.	Гадаргын усны бохирдолтын Үзүүлэлтүүд (рН, жинлэгдэх бодис, ХХХ, БХХ5, фенол, нийт азот, нийт фосфор, сульфид, нийт цианид)	Онги голын уснаас (Дээд боомтын дээрээс, Доод боомтын доороос) Голын ус- 2 цэг Усан сангаас-2 цэг	Жилд 2 удаа	6 цэг	48.0	576.0	MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 3342:1982 Усан мандал. Газрын доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага
	Усны ерөнхий химийн шинжилгээ	Онги голын уснаас (Дээд боомтын дээрээс 1цэг, Доод боомтын доороос 1-цэг) Усан сангаас-2 цэг	Жилд 2 удаа	4 цэгт	25.0	200.0	Хүрээлэн буй орчин Усны ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага 6561:32015
	Бохир усны шинжилгээ (рН, жинлэгдэх бодис, ХХХ, БХХ5, фенол, нийт азот, нийт фосфор, сульфид, нийт цианид)	Бохир ус цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдээд гарч буй уснаас-1 цэг	Жилд 2 удаа	1 цэгт	48.0	96.0	
	Гадаргын усны түвшин хэмжих	Усны харуулын дэргэдээс	Сард 1 удаа	Түвшний хяналтын бүртгэл			
	Усны чанарын шинжилгээний нийт зардал					872.0	
Биологийн төрөл зүйл							
	Амьтны аймаг						
4.	Амьтдын шилжилт хөдөлгөөний ажиглалт, судалгаа явуулах (хөхтөн амьтан, шувуу, загас)		2024-2029 он	Ү/а-ны зардал		Амьтны тухай хууль	
	Загас үржүүлэх судалгаа хийх		2026 он				
	Усны шавжийн судалгаа		2027 он				
Ургамлан нөмрөг хамгаалал							
5.	Ургамлан нөмрөг хамгаалал	Төслийн талбайд тархсан ургамлын зүйлийн бүрдэлийн судалгаа хийх	2024-2029 он	Ү/а-ны зардал		Ургамал хамгаалах тухай хууль	
	Хөрсний чанарын шинжилгээ						



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЯНГА СУМЫН НУТАГТ БАРИГДАХ “3 МВТ-ЫН ХҮЧИН ЧАДАЛТАЙ УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

6.	Хөрсний микробиологийн шинжилгээ	Хог хаягдлын цэг-1 Станц барилга байгууламж ойролцоо-1 цэг	Жилд 2 удаа	2 цэгт 2 удаа	25.0	100.0	MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарт
	Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr гэх мэт)	Станц барилга байгууламж ойролцоо-1 цэг Далангийн ойролцоо-1 цэг			25.0	100.0	MNS 3985:1987 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл
	Хөрсний физик, хими, агрохимийн үзүүлэлт	Усан сан үүсэх талбай орчим-1 цэг Далангийн ойролцоо-1 цэг			25.0	100.0	MNS 2305:1994 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хөрсний чанарын шинжилгээний нийт зардал			300.0			
	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт			2140.0			

Жич: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 05 сарын 06 –ны өдрийн А/164 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



5.10. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байна. Төсөл хэрэгжүүлэгч нь ойролцоогоор 3000.0 м² талбайд ногоон байгууламжийг байгуулах шаардлагатай.

Хүснэгт 11.

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг /мян/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ногоон байгууламж бий болгох	Мод, бут тарих/ хайлаас- 50ш, шар хуайс-50ш/	Төслийн талбайн хэмжээнд	Ширхэг	20	X-5500 Ш.х-3000	85.0	2024-2028	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 4585:2016 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011
	Мандалын цэцэг тарих		кг	6	3500	21.0	2024-2028	
	Зүлэгжүүлэх			100	15000	1500.0	2024-2028	
Хөрс бэлтгэх Нүх бэлтгэх	Хар шороо, элс, бууц худалдан авах	Шороо, элс, бууц	тн	20	35 000	700.0	2024-2028	
	Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ	Ажилчны хөлс	Ажилчин	3	50.0	150.0	2024-2028	
Нийт зардал мян.төг						2456.0		



5.11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах нь удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 12.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, сая төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь					Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он		
Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 ¹ болон БО-ныерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	Гэрээний үнийн дүнгээр						БО-ны мэргэжилтэн	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	Гэрээний үнийн дүнгээр						БО-ны мэргэжилтэн	Газрын тухай хуулийн 58.5
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох						Үйл ажиллагааны менежер	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр						Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр БОАЖЯ –нд хүргэж баталгаажуулах. /Тухайн жилийн БОМТ/	Дотоод төлөвлөлтөөр	1 улирал	Эхний улирал	Эхний улирал	Эхний улирал	Эхний улирал	Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ –нд хүргэж өгөх. /БОМТ-ний биелэлтийн тайлан/	дотоод төлөвлөлтөөр	12 сард	12 сард	12 сард	12 сард	12 сард	БО-ны мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	дотоод төлөвлөлтөөр						БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Нийт зардал мян. төг		-						



5.12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ.

Хүснэгт 13.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах хуваарь /2025он/

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан хүргүүлж тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Жил бүрийн 11 сард	-	БО-ны мэргэжилтэн	БОАЖЯ
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж, тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	-	БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн дүүрэг, багийн иргэдийн хуралд	Хэлэлцүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн талаар Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах болон бусад мэдээллийг	Хагас жил тутам буюу 6, 11 сард	-	Үйл ажиллагааны менежер	Дүүрэг, хорооны иргэдийн хуралд
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Тайлагнах	Үйл ажиллагааны явцад түүхт дурсгалт зүйлс болон соёлын олдвор олдсон тохиолдолд ямар арга хэмжээ авсан талаар	Тухай бүрд	-	БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Засаг даргын тамгын газарт
Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдэд	Тайлагнах	Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;	Тухай бүрд	-	БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Иргэдэд
Нийт зардал мян. төг				-		



5.13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

Хүснэгт 14

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Д.д	Зардлын утга	Нийт зардал сая.төг
1.	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	700.0
2.	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	1400.0
3.	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	800.0
4.	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	1360.0
5.	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	800.0
6.	Түүх, соёлын өвтийг хамгаалах төлөвлөгөөний зардал	-
7.	Осол, эрсдлийн менежментийн зардал	980.0
8.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний зардал	10 000.0
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	2140.0
10.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний зардал	2456.0
11.	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	-
Нийт зардлын дүн		20636.0

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **20636.0** сая.төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.